ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 13 өдөр Дугаар А/04 Мандалговь

Байгууллагад мөрдөгдөж байгаа хууль
тогтоомжийн жагсаалтыг батлах тухай

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.6, 37.1.13 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоол, Газрын даргын 2020 оны А/33 тоот тушаалаар батлагдсан “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэн, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд чанартай тайлагнан ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгтгэн танилцуулж ажиллахыг Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн /Р.Мөнхбат/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцож ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн /Х.Мөнхсаруул/ нарт даалгасугай.

ДАРГА Ц.ГАНЗОРИГ

0820070004
9034137 СБТ11714

48119000